

## ЭРХЭМ ДҮҮ НАРЫНХАА СОНОРТ

Ц. Дэмиддагва

Онц бөгөөд Бүрэн Эрхт Элчин - ахмад дайчин

Ц. Дэмиддагва би 1921 онд төрж, 8 настайгаасаа эхлэн бага, дунд, ЗХУ-д хилийн цэргийн дунд, Монгол улсын их сургуулийн англи хэлний анги, Зөвлөлтөд дипломатын академиин курсыг тус тус завсарлагатай төгссөн бүлгээ.

Би бага дунд сургууль төгсөөд Булган аймгийн Сайхан сумын бичээч, аймгийн хоршоодын холбооны нарийн бичгийн дарга, 1943 оноос ДЯЯ-ны дотоодын ба хязгаарын цэргийн нэгдсэн сургуульд багш, штабын дарга (хичээл ангийн эрхлэгч) - аар ажиллаж байв. 1941 онд Украйнд цэргийн сургуульд сурагч байхдаа Харьковыг хамгаалахаар Эх орны Их дайнд, 1945 онд өөрийн хилийн цэргийн сургуульд штабын дарга байхдаа чөлөөлөх дайнд тус тус оролцсон болно.

1950 оноос 1987 он хүртэл ГЯЯ-нд хэлтэс, газрын дарга, БНМАУ-аас БНХАУ-д суугаа ЭСЯ, БНМАУ-аас НҮБ-д суугаа байнгын төлөөлөгчийн газарт нарийн бичгийн дарга, БНМАУ-аас Энэтхэг, Египет, Солонгос, Алжирт Элчин сайд, Индонез, Балба, Шри Ланка, Этиоп, Сомали зэрэг улсуудад Элчин сайдаар хавсран тус тус ажиллаж байгаад 1987 онд өндөр насны тэтгэвэрт гарсан болно.

Сурагч, оюутан ба ажиллаж байсан он жилүүдэд тохиолдсон зүйлийг дурсах гэвэл барагдахгүй урт юм болж мэднэ. Иймд ганц нэг санаанд байгаа зүйлийг тэмдэглэсү.

Бидний төрсөн нутаг - Монголын сайхан орон бол XX зуунд гэгээ гэрэлтэй, бартаа саадтай замыг тууллаа. Одоо XXI зуунд ард түмэн нүдээ улам том нээж, маш их ухаан зарж "агаарын олгой урсгалд" орох гэж байгаа нисэх хөлөг мэт маш болгоомжтой ажиллах цаг ирж байна. Монголын сайхан орныг дэлхий дахинд бага ч болов мэддэг, дэмждэг балж байна. Харин энэ үед Монголчууд бид хүч чадлаа гаргаж эв нэгдэлтэй, залхуурахгүй материал баялгийн салбарт бага ч гэсэн бүтээл гаргаж эх орноо хөгжүүлэх замд даяршлалыг чадамгай ашиглаж, хэрэгтэй бүхнийг авч, хэрэггүй бүхнийг хаяж "авах гээхийн" ухааныг эзэмших цаг болжээ.

Сүүлийн жилүүдэд хэн дуртай нь гадаад паспорт авч хүлээн авах ямар ч оронд чөлөөтэй зорчих боллоо. Ялангуяа бидний хойт үе залуучууд энэ дэлхийн ямар ч өнцөг буланд явж "юм үзэж, нүд тайлах" болжээ. Гэхдээ нэр төртэй, өөрийгөө захирч элдэв муу муухай юманд орохгүй байх нь гадаадад явагч бүрийн үүрэг юм. "Нэр хугарахаар яс хугар", "Хүн нэрээ, тогос өдөө" гэдэг монголын сайхан зүйр цэцэн үг буй. Үүнийг ямагт санаж явах ёстой. Хилийн чанадад явагчдад юу юунаас түрүүн гадаад хэл, олон улсын хууль хэм хэмжээ зан заншлыг мэдэх хэрэгжүүлэх явдал хамгийн чухал болж байна. "Хэлтэй бол хөлтэй" гэдэг манай ард түмний гүн гүнзгий утгатай зүйр цэцэн үг практик дээр алхам бүрт шаардагдах болжээ.

Гадаад хэлийг сурах олон сургууль дамжаа хичээллэх болов. Харин сурах гадаад хэлээ зөв сонгон авах нь чухал юм. Байдлаас ажиглахад англи, франц хэлийг олон хүмүүс сонгон авч буй бололтой. Энэ бол зүйн хэрэг. Гэвч энэ талаар бас бодох хэд хэдэн зүйл бий. Үүнд: НҮБ-ын албан ёсны таван хэл: англи, франц, орос, хятад, испани, ажлын хэл: англи, франц, орос, араб хэлнээс сонголт хийх нь чухал юм. НҮБ-ын дүрэм - тогтоолд араб хэлийг дээрх зүйлд оруулаагүй боловч зардлыг арабууд өөрсдөө төлж ажлын хэлд араб хэлийг оруулсан тал буй. НҮБ-ын ямар ч хурал зөвлөлгөөнд албан таван хэлний аль нэгээр ярихад бусад албан хэл дээр нэгэн зэрэг орчуулга явагддаг тул эдгээр хэлнээс сонгох нь маш зөв юм. Үүнээс гадна манай хувьд гэвэл хөрш улсынхаа хэлийг сурах нь зүйтэй.

Гадаад хэл сурахад юуны өмнө өдөр тутам хэрэглэдэг үгүүдийг нэн тэргүүнд мэдэх

учиртай.

Хэдэн жилийн өмнө оросууд А.С.Пушкины зохиолд шинжилгээ хийж үзэхэд ярих (говорить) гэдэг үг 1035 дахин давтагдсан байхад гунших (гнусавить) гэдэг үг ганцхан байсныг бодвол Пушкины зохиолыг уншихын тулд "ярих" гэдэг үгийг мэдэхгүй бол бүтэхгүй гэсэн үг. "Гунших" гэдэг үгийг мэдсэн ч мэдээгүй ч бага хэрэг болно. Пушкины зохиол нэг сая үгийн тэмдэгээс бүрдсэн нь нэг үг дунджаар 50 дахин давтагдсан байна. Гадаад хэл сурахад оролцох эрхтэнээ дараалан ажиллуулах нь чухал юм. Үүнд ярих, сонсох, бичих гэх мэт. Үүнээс гадна аль ч хэлэнд байдаг утга нь ил далд хэлэлгийг сайн мэдэх хэрэгтэй аж. Орос хэлэнд "төмөрийг халуун дээр нь давт" гэдгийг монголд буулгахдаа "ямааны мах халуундаа дээр" гэвэл сайхан ойлгогдоно. Мөн сурч байгаа хэлээр ярьдаг улсын түүх, соёл уран зохиол, домог, үгийн гарал үүсвэрийг судлах нь зайлшгүй хэрэгтэй.

Оросууд хэн нэгнээс нөгөө хүнд тус болох гээд муу юм хийсэн байхад "Баавгайн тус хүргэжээ" гэдэг. Үүний учир явдлыг мэдэхгүй бол нөгөө харилцагч юу ч ойлгохгүй өнгөрнө. Үүний үүсэл нь: Баавгай хүн хоёр ижил дасал болсон байжээ. Гэтэл унтаж байгаа хүний нүүрэн дээр ялаа байхыг баавгай хараад ялааг алгартал хүн өөд болсоноос гаралтай гэдэг. Монголоор үүнийг "Нуухыг нь авах гээд нүдийг нь сохолжээ" гэвэл монгол хүн зөв ойлгоно.

Одоо дэлхий дээр ярьдаг олон хэл мартагдаж, ярианы хэл цөөрсөөр байна. Даяршилын үед аль хөгжилтэй орны ярьдаг хэл үлдэж, хоцрогдсон орны хэл юм уу бөглүү орны хэл мартагдаж мэднэ. Гадаад хэл сурч байгаа нь энэ гээд олон хэлээр хольж хутган ярих, бичих нь хүсмээргүй бүдүүлэг явдал юм. Гадаад хэл сурахдаа үндэснийхээ монгол хэлийг гарамгай эзэмшиж харшуулан судлах нь юу юунаас илүү чухал байх.

Орчин үед манай хүмүүс ялангуяа зарим залуучууд телевиз, интернет зэрэг холбооны хэрэгслийг ашиглан ном унших нь тун бага болжээ. Энэ нь цаг хэмнэх, үйл явдлыг бие дүрсээр харах зэрэг давуу тал их байгаа боловч өөрийн орны өнө эртний их түүх, уран зохиол соёлыг мэдэх эзэмших явдал хангалтгүй болох талтай. Монголын соён гийгүүлэгч Инжинааш, Данзанравжаа, Цэвээний Жамсран, Д.Нацагдорж, Бямбын Ринчин, Цэндийн Дамдинсүрэн, Ч.Лувсанжав гэх мэт их хүмүүсийн бүтээл, сургаалыг судлах эзэмших явдал маш чухал байна.

Эдгээр болон монголын бусад нэрт эрдэмтэн зохиолч их хүмүүс өөрийн орны хөгжлийн зам, соёлыг гэрэлтүүлсээр байв. Бүүр мянга есөн зуун дөчин онд Да багш (Ц.Дамдинсүрэн) төрийн сүлд дуулалын үгийг зохиохдоо "Хамаг дэлхийн шударга улстай хамтран нийлсэн эгнээгээ бэхжүүлж ..." гэдэг бадаг хийсэн. Энэ бол тэр үед шууд нэрлээгүй боловч тухайн үед ямар ч харилцаагүй байсан Англи, Америк, Япон, Франц, Герман мэт улстай "холбоо тогтоон ажиллана" л гэсэн үг шүү дээ. Цааш нь "хатан зоригт бүхий чадлаараа хайрт монгол орноо мандуулъя" гэдэг нь эх орныхоо хөгжил дэвшлийн замыг хэн нэг гадаадын зөвлөх сургагч, мэргэжилтний үгээр биш өөрийн хатан зориг чадлаараа шийдвэрлэж бай" гэсэн санаа шүү дээ. Гэтэл хожим нь сүлд дуулалын үг "үндсэрхэг үзэлтэй" байна гэж өөрчилсөн.

Харин ерээд оны ардчилалын хөдөлгөөний дараа Жанцанноров зэрэг хөгжмийн өндөр мэргэжилтэн нар сүлд дуулалын шинэ үг ая дандаа таардаггүй юм гэж Да багшийн зохиосон үгийг үлдээсэн гэдэг.

Бид монголчууд бусдын үгэнд ордог, хууртадаг гэнэн хонгор сэтгэлтэй, асуудалд туйлшран ханддагаа мартмааргүй юм шүү. Ийм явдал эртний болон өдгөөгийн бид нарт элбэг байдаг сул тал юмуудаа. Бүүр XIII зуунд монголын нийслэл Хархорумд монголын дархчуудтай хамтран францын дархан Гийом Бушэ, Оросын дархан Кузьма нарын босгосон дөрвөн лууны амаар дарс, айраг, зөгийн бал, тутаргын исгүүн ундааг олонд түгээдэг мөнгөн модны оройд харийн гүрний хүмүүсийн шахалт залиар Загалмайн шүтээн алтан бүрээт Ангел бурханыг залж монголчууд өөрийн төлөвлөж байсан нар сарыг уг модны оройд залж чадаагүй юм.

Өдгөө монголчууд бид даян дэлхийн шударга түмэнтэй хүч чадлаа нэгтгэн Лхозамбуулэнгийн муу муухай бүхэнтэй хатуу тэмцэж, улс түмний сайн бүхэнд хүч чадлынхаа хэрээр хувь нэмэр оруулж, өөрийн хүчээр үл чадах бүхнийг хамтын хүчээр даван туулах нь дэвшилт хүн төрөлхтний өмнө тавигдаж байгаа зорилгод нийцэх бизээ. Байгаль цаг уурын гай гамшиг, цаг агаарын эрс тэс өөрчлөлтийн хор уршгийг зөвхөн хамтын хүч - даяршлалын дэмжлэгээр туулж болно. Хуурай уур амьсгалтай, далайн түвшнээс их өндөр газар нутагтай, хүчтэй салхины нөлөөнд байдаг, гол мөрөн нь бүгд (хаалт халхавч байхгүй) гадаадад урсан гардаг, хур борооны ус зөвхөн газрын хелефээр урсан оддог бидний эх оронд байгалийн аюул учрахгүй гэх ямар ч баталгаа байхгүйг бид хэзээ ч мартаж болохгүй.

Монголчууд - монгол үндэстэнд ойрын үед хийх бүтээх ажил их байна. Монголын үндэсний хувьсгалын 100 жилийн ой 2011 онд, Чингис хааны мэндэлсний 850 жилийн ой 2012 онд болно. Эдгээр ойг тэмдэглэхдээ шийдвэрлээгүй асуудал бүхэнд анхаарлаа төвлөрүүлж залуу үеэ эх орондоо хязгааргүй хайртай болгох олон талтай шинэ арга хэмжээнүүдийг зохиогоосой.